

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН БАТЛАМЖИЙН БИЕЛЭЛТ

2022.12.14

Хуурч

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Засаг дарга Ц.Баянбаатар миний бие нь Сэлэнгэ аймгийн Засаг дарга, түүний ажлын албаны өмнө сумынхаа хөгжил дэвшлийг эрс эрчимжүүлж, орон нутгийн засаглалыг тогтвортой мэргэжлийн ур чадвартай байхаар чадавхжуулан, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, сурч боловсрох, ажиллах, амьдрах нөхцөлийг бүрэн хангах бодлого чиглэлийг тууштайгаар шуурхай, шударга, хариуцлагатайгаар хэрэгжүүлэхийн төлөө үүрэг, зарчмуудыг мөрдлөг болгон дараах ажил үүргийг гүйцэтгэлээ.

1.Монгол Улсын хуулийг чандлан сахиж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллана.

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ёс зүйн зөрчилгүй ажиллалаа.

2.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүнд нийцүүлэн гаргасан Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сумандаа бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллана.

Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлтийг албан хаагч тус бүрт хариуцуулан биелэлтийг ханган ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газар, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумын 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, 2022 оны Зарласан жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг орон нутагтаа хэрэгжүүлэх, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх, байгууллага аж ахуйн нэгжүүд, багуудын хэвийн үйл ажиллагааг хангахад удирдлага, арга зүйгээр хангах, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эрхэм зорилгоо "Төрийн бодлого зохицуулалт ард иргэдийнхээ бүтээлч оролцоонд тулгуурлан тэдний ая тухтай амьдрах бүхий л боломжийг бүрдүүлсэн жишиг сум байна" гэсэн уриатайгаар тодорхойлж 5 үндсэн бодлого чиглэлийн хүрээнд 168 зорилтыг тусгаж сумын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллалаа.

3.Сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын чиглэлийг баримтлан улсын хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, сумын төвийн замыг хатуу хучилттай болгох 6.2 тэрбум төгрөгийг батлуулж хэрэгжүүлж байна. Мөн аймгийн хөрөнгө оруулалтаар 370 сая, сумын хөрөнгө оруулалт, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 1,3 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт хийсэн

4.Дээд шатны байгууллагын бодлого шийдвэрийг орон нутгийн онцлогт нийцүүлэн шуурхай хэрэгжүүлнэ.

1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд:

2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар зохион байгуулагдаж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сумандаа "Тэрбум мод-Цагааннуур-2022" зөвлөгөөн,

үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг Сэлэнгэ бүсэд хэрхэн хэрэгжүүлэх арга зам, оролцоо, тарьц суулгац бэлтгэх, ойжуулалт, мод үржүүлэг, жимс жимсгэний мод тарьж ургуулах техник технологи, усалгаа арчилгааны талаар иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэлээ. Мөн мод, бут, сөөгний үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн эдэлбэр газарт шинээр 6 ширхэг бичил цэцэрлэг 3 га-д байгуулж, нарс 258 ширхэг, гоёлын мод 360 ширхэг, иргэд гоёлын мод 21 ширхэг, жимсний мод 69 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод 82 ширхэг, жимсний мод 184 ширхгийг тус тус тарьсан байна. Сумын хэмжээнд нийт шилмүүст мод 258 ширхэг, гоёлын мод 381 ширхэг, жимсний мод 253 буюу нийт 892 ширхгийг тарьсан.

Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн 0,35 сот газарт мөчрөөр болон үрээр шар хуайс 2кг, буйлс 1кг, агч 3кг тус тус үрийг тарьсан. Үүнээс буйлс 650 ширхэг, шар хуайс 9700 ширхэг, агч 8900 ширхэг нь үрсэлж ургасан. Шүрэнгийн зам ХХК нь хавар 232м² талбайд өрөл 4кг, гүйлс 500гр, тэхийн шээг 2кг, агч 1кг, голт бор 1кг, буйлс 6кг үрээр тарьсан бөгөөд 85% ургалттай байна. Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн нөөцөд нарс 2кг, шинэс 2кг, гацуур 2кг, шар хуайс 2кг, агч 500гр, монос 2кг, хуш 5кг, Шүрэнгийн зам ХХК-ийн нөөцөд гүйлс 13000кг, буйлс 5кг, монос 2кг, агч 2кг тарих үр байна.



2. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа

Өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нутгийн брэнд бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагдсан "Цагааннуур ургац-2022" өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа болж өндөрлөлөө. Үзэсгэлэн худалдаанд 24 иргэн 14 нэр төрлийн бүтээгдэхүүнээ танилцуулан оролцсон бөгөөд 5 төрлийн "Шилдэг бүтээгдэхүүн"-ийг шалгаруулж урамшуулсан.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн хүрээнд “Сэлэнгэ-Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээ 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан. Уг арга хэмжээнд сумын жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгч 6 иргэн 5 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 1 дүгээр багийн иргэн Д.Нарантуяа бэлгийн багц бүтээгдэхүүнээрээ шагнал хүртэж амжилттай оролцлоо.



3. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын тооллого

Орон нутгийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого болохтой холбогдуулан явагдсан сургалтад төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, нягтлан бодогч, эд хариуцагч нийт 18 албан хаагч хамрагдсан.

Улсын үзлэг тооллогод сумын төсвийн 9 байгууллага хамрагдаж, орон нутгийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого хийж, эд хөрөнгийн болон бусад мэдээллийг программд бүрэн оруулж дууссан. Уг ажлын хүрээнд аймгийн эд хөрөнгийн үзлэг тооллогын ажлын хэсэг суманд ажиллаж, эд хөрөнгийг түүврийн аргаар нүд үзэн чанар, бүрэн бүтэн байдалтай танилцлаа. Тооллогын үеэр гарсан зөрчил дутагдлыг засаж сайжруулах зөвлөгөө зөвлөмж, албан даалгавар өгсөн.



4. ХАА-н улсын тооллого

Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/69 тоот захирамжаар ХАА-н тооллого явуулах 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажилласан.

Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй малчин болон мал бүхий, газар тариалан эрхэлдэг давхардсан тоогоор 402 өрх, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тооллогод хамруулсан. Үүнд:

- Газар тариалан эрхэлдэг өрх-82
- Газар тариалан эрхэлдэг ААНБ-31
- Мал аж ахуй эрхэлдэг өрх -276
- Мал аж ахуй эрхэлдэг ААНБ -11

➤ Ойн аж ахуй эрхэлдэг өрх -1 тус тус хамрагдсан.



5. Автотээврийн улсын үзлэг

2022 оны 05-р сарын 25-27 ний өдрүүдэд авто тээврийн улсын үзлэг болж нийт 687 тээврийн хэрэгсэл, үүнээс суудлын автомашин 355, ачааны автомашин 294, зүтгүүр 1, автобус 4, цэстэрн 2, тусгай зориулалтын 2, механизм 8, чиргүүл 4, мотоцикл 17 тус тус хамрагдсан.



6. Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт шалгалт

Суманд хүнсний бараа, түүхий эдийн аюулгүй байдлыг хангуулах, хүнсээр дамжих элдэв халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ажлын хэсэг гарч 3 удаагийн хяналт шалгалтыг хийсэн. Нийт давхардсан тоогоор 22 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. Шалгалтаар 74 нэр төрлийн /2сая 300мянга/ төгрөгний хүнсний бүтээгдэхүүн лангуунаас татуулан буцаалт хийлгүүлж, 120 гаруй нэр төрлийн /1 сая 970 мян/ төгрөгний хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг байгууллагын дотоод хяналтын журмын дагуу устгуулж ажилласан. Шалгалтаар 194 зөрчил илрүүлэн 180 буюу 92.7 хувийг арилгасан. Илэрсэн зөрчлийн 40 хувь нь шошгын мэдээллийг бүрэн тусгаагүй, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан, гарал үүсэл нь тодорхойгүй, хадгалалтын горим алдагдсан, хугацаа дууссан зэрэг зөрчлүүд илэрч байна.



7. Цэрэг татлага

Аймгийн Засаг даргын 2022 оны А/03 тоот захирамжийн дагуу цэргийн бүртгэлийн 01 дүгээр сарын 07-21-ний өдрүүдэд зохион байгуулж 1, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтний дэлгэрэнгүй бүртгэлийг аймгийн Цэргийн штабт хүргүүлсэн. 2022 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулж 35 цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, 2 иргэн цэргийн албанд татагдсан. 2022 оны 1-р ээлжийн цэрэг татлагад 35 залуу хамрагдснаас 1 иргэн тэнцсэн, 2-р ээлжийн цэрэг татлагад 50 залуу хамрагдснаас 18 иргэн тэнцэж цэргийн албанд татагдсан.



8. Цэрэг спортын “Дөл” тэмцээн

Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын нэрэмжит сумын аварга шалгаруулах Цэрэг-Спортын “Дөл” тэмцээн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр суманд явуулж улмаар бүсийн сумдаас шалгарсан багуудын дунд Сэлэнгэ бүсийн сумдуудын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.



9. Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль

Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль 06 сарын 3-5-ны өдрүүдэд “Танхимын сургалт”, “Бэлэн байдлын үзлэг”, “Штабын дадлага”, “Дадлага, сургууль” гэсэн үндсэн дөрвөн хэсэгтэйгээр явагдсан. Штабын дадлага сургууль нь сумын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин болсон үеийн удирдлагын хариу арга хэмжээ, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн анги, албадын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох, өгөгдсөн цагийн байдлын дагуу бүлгээр ажиллах дадлагаар явагдсан. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн иргэдийг аюулгүй нүүн шилжих дадлага суруульд нийт 689 иргэн хамрагдсан.




5. Сумынхаа хэмжээнд сахилга, хариуцлагыг эрс сайжруулан нутаг дэвсгэрийн байгууллага, тосгон, багт тогтмол ажиллаж, өөр аймаг, гадаад улсад албан томилолтоор ажиллах тохиолдолд аймгийн Засаг даргын Тамгын газраар удирдамжийг батлуулан үр дүнг тайлагнана.

1. Төрийн албан хаагчийг ажлын байранд нь чадавхжуулах, харилцаа, хандлага, ажлын үр дүн, гүйцэтгэл, ур чадварыг нэмэгдүүлэх онол, практик, олон улсын туршлагын шинэ мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор 42 төрийн албан хаагч цахимаар хамрагдлаа.



Сумын Засаг даргын Тамгын газрын 28 албан хаагчийг Монголын нутгийн удирдлагын холбооны лектор багш нараар “Хувь хүний хөгжил, хандлага” “Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлага” сэдэвт сургалтуудад хамруулсан



2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдамжийн дагуу Орос-Монголын аж үйлдвэрийн форумд сумын Засаг дарга төлөөлөгчөөр оролцсон.

6.Нутгийн захиргааны ажлыг шударга, ил тод, хүнд сурталгүй удирдан чиглүүлж, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжин ажиллаж, иргэдийг ажлын байраар хангах замаар өрх бүрийг ажилтай, орлоготой болгон амьдралын чанарыг сайжруулна.


1. Өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нутгийн брэнд бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Цагааннуур ургац-2022” өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа болж өндөрлөлөө. Үзэсгэлэн худалдаанд 24 иргэн 14 нэр төрлийн бүтээгдэхүүнээ танилцуулан оролцсон бөгөөд 5 төрлийн “ Шилдэг бүтээгдэхүүн”-ийг шалгаруулж урамшуулсан.




Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн хүрээнд “Сэлэнгэ-Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээ 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан. Уг арга хэмжээнд сумын жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгч 6 иргэн 5 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 1 дүгээр багийн иргэн Д.Нарантуяа бэлгийн багц бүтээгдэхүүнээрээ шагнал хүртэж амжилттай оролцлоо.



2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, худалдан авах ажиллагааг 100 хувь цахим системээр мэдээлж байна.



- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, аймгийн Засаг даргын 2021 оны “Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай” А/177 дугаар захирамжийн хүрээнд
- 1-3 дугаар улирлын үйл ажиллагааны тайланг “Нуурын мэдээ” сэтгүүлд нийтлэн иргэдэд тараасан.
 - Төсөв санхүү, Хүний нөөц, сул орон тоо, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг тухай бүр албан ёсны цахим хаягуудад ил тод нээлттэй байршуулж байна.



3. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийн LMIS программд идэвхтэй ажил хайгчаар 130 иргэн, ажил олгогч 45 ААНБайгууллагыг бүртгэж, 88 иргэнийг шинэ ажлын байранд зуучилсан.

“Уран шаглаа” оёдолын төслөөр 1 иргэнд 5 сая төгрөг, 1 иргэнд “Талх”-ны цехээр 10 сая төгрөгийг 36 сарын хугацаатай 100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгээр

олгосон. Төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу ашиглаж үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, эргэн төлөлтийг хугацаанд нь хийж байна.

“Малжуулах төсөл хөтөлбөр”-ийн хүрээнд:

1 иргэнд 20 хонь, 10 ямааг 5 сая төгрөгөөр, 1 иргэнд 3 тугалтай үнээ, 1 шүдлэн үхэрийг 5 сая төгрөгийг 36 сарын хугацаатай эргэн төлөх нөхцөлтэйгээр олгосон.

“Ахмадын ажлын байрыг дэмжих” төсөл хөтөлбөрийн хүрээнд:

1 ахмад настанд “Төмөр хийц” төслөөр 5 сая төгрөгийг 24 сарын хугацаатай олгосон ба төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу тоног төхөөрөмж худалдан авч ажлын байраа өртгөн үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” арга хэмжээнд:

1 иргэн “Түүхий эд”-ээр төсөл бичиж 8 сая төгрөгийг 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэйгээр авч зориулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.



Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний газар, Цагааннуур сумын Засаг даргын тамгын газар хамтарсан гэрээ байгуулан 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 7 хоногийн хугацаатай нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн торон хашааг барих ажилд ажилгүй 10 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, түр ажлын байраар ханган өрхийн орлогыг нь дэмжин ажилласан.



7. Аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газраас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, албан үүргээ хангалтгүй биелүүлэх, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах, хууль зөрчиж албан тушаал, төрийн эрх мэдлийг хувийн зорилгоор ашиглах, авилга, хээл хахууль өгөх, авах ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд Засаг даргын үүрэгт ажлаас шууд татгалзаж, төрийн хууль тогтоомжийн дагуу шийтгэл, хариуцлага хүлээнэ.

2022 оны 02 дугаар сарын 21-ны өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газраас ажлын хэсэг ажиллаж сумын Засаг даргын Тамгын газар болон төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хяналт шалгалтын үр дүнгээр 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Засаг даргын захирамжаар Цагааннуур сум нь Аймгийн “Тэргүүний сум”-аар шалгарсан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон хурлын хяналт шалгалтын ажлын хэсэг 2022 онд суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон

аймаг, сумын хөрөнгө оруулалтаар хөрөнгөөр хийгдсэн 14 ажил үйлчилгээний явц, гүйцэтгэлд 1-3 удаа хяналт тавьж, зөвлөмж хүргүүлэн ажилласан.

2022 онд Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитаас 2021 оны санхүүгийн гүйцэтгэлийн аудит, Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, Аудитын албаны төлөвлөгөөт хяналт шалгалт тус бүр 1 удаа, 2021, 2022 оны эхний хагас жилийн сумын дотоод хяналт шалгалтыг 3 удаа хийгдсэн.

2021 оны Сумын 2021 оны сумын хөгжлийн төлөвлөгөөний биелэлт 87,5 хувьтай үнэлэгдсэн.

Тайлант хугацаанд дээд газраас өгсөн үүрэг даалгаврыг чанартай биелүүлэхэд анхаарч, ёс зүйн зөрчил, дутагдалгүй ажилласан.

ЗАСАГ ДАРГА

Ц.БАЯНБААТАР